

# МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№20/524

ШУС, НУС

2019

### МОНГОЛ ҮНДЭСТНЭЭС ТӨРСӨН АНХНЫ ОЛОН УЛСЫН СЭТГҮҮЛЧ

Л.Норовсүрэн\*

\*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн гэрээт профессор, Шинжлэх ухааны доктор (Sc.D)

**Түлхүүр үг:** Залуучуудын эвлэл, Гоминдан, шорон, англи хэл, багш, зөрчил, тэнүүл ард, Черчилль, Сан-Франциско, сэтгүүлч, НҮБ.

**М**онгол туургатны дундаас төрж гарсан хамгийн баялаг намтар түүхтэй, сонин хувь тавилантай сэтгүүлч бол Татаармөрөн мөн. Энэ хүн уг гарлаараа монгол үндэстэн боловч хувь заяаны эрхээр монгол хэл, монгол үндэс угсаагаа ч мэдэхгүй өсч хүмүүжсэн байна. Түүний дээдсийн нутгийг ном зохиолд Хөлөн буйр, Их Хянган даваа, Үзэмчин гэх мэт өөр өөрөөр бичсэн байдаг.

Татаармөрөнгийн хятад нэрийг Сюү Чянь гэдэг байв. Тэрээр 1910 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр Бээжингийн нэгэн ядуу эмэгтэйн гэр бүлд төржээ. Эцэг нь түүнийг төрөхөөс өмнөхөн нас барсан байна. Татаармөрөнгийн эцэг хар багаасаа хятадын нутгийн гүнд өсч торнисон тул хятад эхнэр авчээ. Эхнэр нь ажилсаг хичээнгүй, найрсаг тусархуу, амьдралд хатуужилтай, аливаад эв дүйтэй нэгэн байсан гэдэг. Бэлэвсэн эх нь Татаармөрөнг зургаан настай байхад Бээжингийн нэгэн сүмд шавь оруулжээ. Тэр сүмийн сургууль тохь тухгүйн дээр багш нь ном заахаасаа илүү толгой түрүүгүй зодож занчдаг байв. Татаар-

мөрөн энэ мэт хоёр ч сургуулийг дамжсаны дараа аз таарч Америкийн шашны байгууллагын сурч хөдөлмөрлөх хосолсон хөтөлбөртэй төлбөргүй сургуульд орж, бага ч гэсэн тэтгэлэг авдаг болжээ.

Уг сургуульд ороод анхныхаа тэтгэлгийг авч баяр хөөртэй харьж ирэхэд хайрт эх нь хорвоогийн мөнх бусыг үзүүлсэн<sup>1</sup> байжээ. Татаармөрөн ингэж орчлонд ганцхан удаа олддог өмөг түшгээсээ хагацсан байна. Хан хорвоод орь ганцаар үлдсэн хүү хайрт эхээ дурсан бичихдээ «Ээж минь надад оргилоод зогсошгүй халуун сэтгэл олгож, чин танилт ба халуун сэтгэлээр хүний амьдралтай ойртохыг сургасан»<sup>2</sup> гэсэн байдаг.

Далаад онд Бээжингийн радио-гоор цацагдсан нэгэн нэвтрүүлэгт Татаармөрөнгийн бага насны эмгэнэлт амьдралын тухай өгүүлэхдээ «Бяцхан хүү анхныхаа цалингаас нэг лонх биржгэр луугийн нүдтэй шимт жимс авч ирэхэд эх нь нүдээ нээж, үг хэлж чадахгүй болсон байв. Гэвч ариун цагаан хөдөлмөрийнхөө үр шим болсон амтат жимсийг аманд нь зуулгаж байгаа тэр хүн бол аминаас тасарсан амь болох алдрай хүү минь гэдгийг совингоороо мэдсэн байж таарна. Тийнхүү хайрт эх нь хүүгийнхээ үмхүүлсэн

жимсийг сүүлчийн удаа залгиад ертөнцөөс хальжээ»<sup>3</sup> хэмээн сэтгэл шимшрүүлэн өгүүлсэн байдаг.

Эцэг, эхээсээ өнчирч хоцорсон айлын ганц хүү сайн сургууль сонгож, сонирхсон мэргэжлээ эзэмшихийг хүссэн ч өмөг түшиг, бэл мөнгөгүйн зовлонг туулж өнгөрөхөөс, тойрч гарах аргагүй байлаа. Зургаан настайдаа сургуулийн босго алхсан тэрбээр дөрвөн жилийн дотор гурван сургууль дамжсан байна. Цүнши дунд сургуульд ажиллах, сурахыг хослуулж байхдаа хувьсгалч хүмүүстэй танилцаж, улмаар Эв хамт залуучуудын эвлэлд элсэж коммунизмын сургаал дэлгэрүүлсэн хэргээр Гоминданы шоронд сууж үзэв. Анхан шатны дунд сургуулиа төгсөөд нэгэн хэвлэлийн газарт ажиллах болсон нь түүний амьдралд эргэлт гаргасан байна. Тэнд хэдийгээр гуравхан сар ажилласан боловч ажил хөдөлмөрийн дөртэй болж, тус хэвлэлийн газраас гаргасан «Хашгираан», «Хээрийн өвс» гэх мэт олон ном зохиол уншиж, чамлалтгүй мэдлэг хуримтлуулсны дээр утга зохиолын үйл хэрэгт зүтгэхээр сэтгэл шулууджээ.

Тийнхүү ажиллаж байхдаа бусдыг ажил хаяхад уруу татсан шалтгаанаар халагдаж хийх ажилгүй хэсэг хугацаа өнгөрсний дараа сайн нөхрийн дэмжлэгээр сургуульдаа эргэн ирж Сурагчийн зөвлөлийн эрхлэгч, сургуулийн сонины утга зохиолын ажилтан болов. Ажлын хажуугаар ахлах дунд сургуульд орж суралцсан байна. Тэрбээр шашны суртал нэвтрүүлгээс иргэний сургуулийг хамгаалах үзлээсээ болж төгсөхөөсөө ганцхан жилийн өмнө буюу 1927 онд сургуулиасаа дахин хөөгджээ.

Татаармөрөнг тийнхүү барьц алдаж явахад нэгэн танил нь Гуандунд очиж багшлахыг урьжээ. Гоминданы

хар данснаас салахыг хүсч байсан тул тэр дор нь зөвшөөрч Шанду хотын Жиюүши дунд сургуульд хэлбичгийн багшаар ажиллажээ. Энд ажиллаж байх хугацаанд сурагчдад ном цээжлүүлэх биш, зохион бичүүлэх, сонин сэтгүүлд бичиж найруулах дадлагыг түлхүү хийлгэдэг байв. Татаармөрөн эндээс үзэл бодлын зөрчлөөс биш, харин үргэлжлэн суралцах шаардлагаар Бээжинд дахин иржээ. Тэгээд Бээжингийн таван алдартай сургуулийн нэг Фүрвэ их сургуульд элсэж Лейдмэн ламын шавь болж хоёр жил суралцсан байна.

**Т**атаармөрөн 1932 онд Фүжеү хотын Янхуа дунд сургуульд хэлбичгийн багш болов. Тэнд нэг жил багшлаад дахин Бээжинд ирж Янжин Их Суруульд залган суралцсан байна. Түүнийг 1935 онд тус сургуулийн сэтгүүлчийн салбарыг төгсөх гэж байхад нь Тяньжингийн «Дэгүн» сонины редактор Ху Лин сониндоо ажиллуулах санал тавьжээ. Тэрбээр «Дэгүн» сонины сурвалжлагч болсноор сурагч, оюутны амьдралаа үдлээ гэж бодсон ч, тийм биш байжээ. Долоон жил ажилласны эцэст английн зохиолч Фүстэ, эрдэмтэн Асе, Вейли нар түүнийг Кембрижийн Их Сургуулийн англи хэлний ангид оруулсан байна.

“Эрдэм мэдлэг эзэмших, ялангуяа хичээлийн танхимд сууж, ном бичиг үзэх дуртай тэрбээр анхаарал татсан ном зохиолыг өдөр, шинийн турш тавилгүй унших нь ердийн хэрэг байв. Хүний нэг насны амьдрал бол нэг л удаагийн аялал мөн гэж тэр үздэг байжээ. Аялах явцад сайн сайхнаас гадна таниж мэдэхгүй юм арвин тохиолдоно. Зарим хүн бэрхшээлийн өмнө толгой бөхийнэ, зарим нь гутарч гунина. Татаармөрөнд тийм бэрхшээл олон тааралдаж байлаа. Хоолгүй хонох,

хавчигдан гадуурхагдах, сурлагын төлбөрөө төлж чадахгүй болох, цаашлаад Гоминданы шоронд хоригдсон гээд алийг хэлж барах билээ. Хал үзэж, халуун чулуу долоосон ч амьдрахын төлөө хүчлэн зүтгэж, туулсан замдаа тод мөр үлдээж чадсан юм<sup>4</sup>.

**Т**атаармөрөн Англид очсоны дараа Германы агаарын хүчний бөмбөгдөлтөнд өртсөн байшингийн нурангинд дарагдаж амь алдах шахжээ. Бас дайны талбарт сурвалжлага хийж яваад бууны суманд оногдох дөхөв. Өлсөх, даарах мэт энгийн хүнд тохиолддог бэрхшээл бол түүний хувьд амьдралынх нь хэв маяг байсан юм. Үүнийг нь «Би хэзээ ч гутардаггүй. Соёлын хувьсгалын үед үхэх гэж унтуулах эм залгиж байхдаа ч гутарч байгаагүй. Харин зэрлэг балмадаар гутаан доромжлохыг л тэвчиж чаддаггүй» гэсэн түүнийг үг батална. Соёлын хувьсгалын үед тэр үнэхээр ял зэмлэлд хилсээр унаж, адгийн муугаар дарлагдаж явжээ. Гэвч тэр ард түмэн, улс гэрийнхээ ирээдүйд бат итгэж, гуйвалтгүй тэмцсэн юм.

Татаармөрөн Кембрижийн Их Сургуулийг дүүргээд тэндээ үлдэх үү, нутаг буцах уу? гэсэн хоёр сонголтын аль нэгийг хийх хэрэгтэй болжээ. Хангалуун нөхцөл амлаж, Англид үлдээх санал ирж байсан ч нутгаа зорихоор шийдлээ. Нутагтаа буцаж ирсний дараа бас л баруунтан хэмээн сэжиглэгдэж, соёлын хувьсгалын шуурганд өртөн хал зовлонг ханатлаа амслаа. Тэр бүхнийг нугаршгүй зориг тэвчээрээр даван туулж байв.

Тэрбээр монгол үндэстэн болсны хувьд Өвөрмонголд очих дуртай байлаа. 1930, 1934 онд завшаан таарч нутагтаа очжээ. Сүүлчийн удаа очихдоо Өвөр Монголын байдлыг ойлгож, төмөр замын ажилчдын эрхэлсэн ажилдаа

дадамгай, хатуужил тэсвэртэй байдлыг танин мэджээ. Датүнгийн нүүрсний уурхайд очиж ажилчдын цалин мөнгө бага, амь нас нь баталгаагүй, ажиллах орчин нь харанхуй нойтон байгааг үзлээ. Ядуу зүдүү бүсгүйчүүд амьдрахын аргагүй болж биеэ худалдаж байгааг харлаа. Тэнд номин ногоон бэлчээр байхгүй, харин өнгө ялгарсан хар тамхины цэцэг газар болгонд дэлгэрч байгааг үзлээ. Хэрэмний хананд хар тамхины хор тайлах зар наагдаж байхад, тамхи татах пүүсэнд цагаан утаа манарч, тамхичид хөндлөн гулд хэвтэж байгааг харлаа. Энэ аяллаас буцаж ирсэн хойноо «Пинсүй замаар аялсан сул тэмдэглэл» гэдэг алдартай нийтлэлээ бичсэн байна.

Татаармөрөнгийн алдартай бүтээлийн нэг нь «Цус махаар дэвсэгдсэн Диен Миен зам» гэдэг нийтлэл юм. Дундад улсад өрнөсөн Японыг эсэргүүцэх дайн шийдвэрлэх шатандаа ороод байсан 1940 оны 7 дугаар сард Черчилль японы түрэмгийлэгчдэд завшаан олгох далд санаагаар тухайн үед Английн харьяанд байсан Бирмээс Дундад улс руу нэвтрэх засмал замыг хаасан байна. Уг зам Дундад улсын хувьд маш чухал байгууламж байлаа. Учир нь тэр замаар Дундад улсад оруулах зэр зэвсэг, машин, тоног төхөөрөмж, эм тан, түүний хариуд гаргах вольфрам, гахайн зогдор, мөнгөн ус зэргийг зөөвөрлөдөг байсан юм. Диен Миен замаар өдөрт дунджаар долоон мянган машин зорчдог бөгөөд оруулж, гаргах бараа таваар нь хэдэн арван мянгаар тоологдож байв. Уг замыг хаасан нь үнэн чанартаа Дундад улсын багалзуурыг базсан хэрэг байлаа.

Татаармөрөн Диен Миен замыг сурвалжлан бичсэн тэмдэглэлийнхээ эхэнд уг замын ерөнхий байдлыг танилцуулж, зам тавихад хүч хөдөлмөр, амь

насаа хайрлалгүй зүтгэсэн хүмүүстэй уулзаж, тэдний үйл хөдлөл, үг яриаг амьд сонирхолтой дүрсэлсэн байна. Уг замыг тавигчид унтаж хэвтэх ор дэр, ууж идэх хоол хүнсгүй шахам нөхцөлд өдөр шөнөгүй зүтгэж, хүнд хөдөлмөрт нухлагдахын зэрэгцээ элдэв хадварт өвчинд нэрвэгдэж үхэж үрэгдэх нь ердийн хэрэг болсныг илчлэн бичсэн байна. Зохиогч Диен Миен замын цар хүрээг илтгэхдээ нийт 973 километрийн урттай бөгөөд замын дагууд 370 гүүр, 1,4 сая чулуун багана, хоёр мянга шахам барилгыг ганц ч машин техникгүйгээр зөвхөн хэдэн зуун мянган ажилчны хөлс хүчинд түшиглэн барьж байгааг онцлон тэмдэглэсэн байдаг.

Татаармөрөн 1939 оны хавар уг замыг барьж байгаа ажилчидтай хамт амьдарч, хооллож ундлан, нөхцөл байдлыг нарийн судалж мэдсэний үндсэн дээр уг тэмдэглэлээ бичсэн байна. Дэлхийн II дайны түймэр Европд ид дүрэлзэж эхлэх үед тэрбээр Англид очжээ. Тухайн үед Черчилийн шийдвэрээр хаагдаад байсан Диен Миен замыг сурвалжилсан Дундад улсын сурвалжлагчийн хувиар уг замын бодит байдлыг английн ард түмэнд танилцуулж амжлаа. Англи дахь Дундад улсад туслах зөвлөлийнхөнтэй хавсран гудамжны сүрт жагсаал зохион байгуулж, Черчилийн ажлын өргөөний өмнө очиж Диен Миен замыг хаасныг эсэргүүцсэн байна. Уг тэмцлийн үр дүнд Английн Засгийн газар уг замыг арга буюу нээсэн юм.

Татаармөрөн Англид байх хугацаандаа тус улсын сайн санаат хүмүүсийн санаачилгаар Японы түрэмгийллийг эсэргүүцэж байгуулсан «Дундад улсыг дэмжих хурал» хэмээх байгууллагын гишүүн болж ухуулгын ажилд идэвхтэй оролцож байлаа. Тэрбээр эхлээд сард хоёр удаа олон

нийтэд мэдээлэл хийдэг байснаа сүүлдээ долоо хоног бүр мэдээлэл хийдэг болов. Түүний мэдээллийг хүмүүс янз бүрээр хүлээн авдаг байв. Зарим нь эсэргүүцэж Черчилийн төлөө үг хэлж байхад, зарим нь Татаармөрөний өмнөөс босч түрэмгийллийн эсрэг тэмцсэн Дундадын ард түмнийг дэмждэг байлаа. Тэрбээр энэ завсар дундад улсын Шандун мужийн баруун хэсгийн ард иргэдийн амьдралыг харуулсан «Лусигийн тэнүүл ард» гэдэг алдартай нийтлэлээ олон нийтийн хүртээл болгоод байсан юм.

“Энэ үеэс Татаармөрөн улс төрийн үйл ажиллагаанд биеэр оролцож эхэлсэн байдаг. Тэрбээр Дэлхийн II дайны Европын фронтыг сурвалжилсан цорын ганц монгол сэтгүүлч юм. Энэ нь түүний сэтгүүлчийн үйл ажиллагааны оргил хэсгийн нэг байв. Татаармөрөн 1939-1946 оныг хүртэлх бүтэн долоон жилийг энэ үйлсэд зарцуулж, Европоос Умард Америк хүртэлх урт замыг туулсан юм. Энэ хугацаанд тэрбээр дайны фронтод нэвтэрч, засаг төр, цэргийн эрхтнүүдтэй уулзаж, олон улсын томоохон хурал чуулганд оролцох зэргээр сэтгүүлч хүний хүрч болох газар бүхэнд хүрч байв”<sup>5</sup>.

Татаармөрөнгийн Англид очсон уг шалтгаан нь 1939 онд Лондонгийн Их Сургуулийн Дорно дахины салбарт багшаар уригдсан явдал ажээ. Тус сургуульд багшлахын зэрэгцээ «Дэгүн» сонины Англид суух сурвалжлагчийн үүргийг хүлээж байв. Тэрбээр долоон жилийн туршид Дундад улсын байдлыг англичуудад таниулах, дэлхийн II дайны явцыг Дундадынханд мэдээлэх хоёр талт үүргийг гүйцэтгэж байлаа. Татаармөрөн Европын дайны талбараас олон тооны мэдээ, сурвалжлага, тэмдэглэл, найруулал бэлтгэж «Дэгүн» сониндоо

илгээж байв. Түүний нийтлэл олон нийтийн хүсэн хүлээсэн чухал асуудал байхын зэрэгцээ үнэн бодитой хэргийг өвөрмөц арга барилаар илэрхийлж чаддагаараа Дундад улс төдийгүй Европ дахинд алдаршсан билээ.

Түүний нийтлэлүүдийн дотор «Хоёрдугаар их дайны Европын фронт дахь Дундадын нэгэн сурвалжлагчийн олон мөр», «Хоёрдугаар их дайны Европын байлдааны тухай Дундадын нэгэн сурвалжлагчийн төрөгдөл», «Өмнөд Германы гүн намар», «Берлинд хүрсэн тэр удаа», «Мюнхений хэлэлцээр-хоёрдугаар их дайны тодруулал» зэрэг бүтээлүүд ихэд нэрд гарчээ.

Татаармөрөн 1945 оны 2 дугаар сард Америкийн долдугаар армитай хамт сурвалжлагаар явжээ. Долдугаар армийнхан Германы Рейн мөрний том гүүрийг эзэлж аваад Берлин рүү давшиж байх үед Лондон дахь хэрэг эрхлэх газраас ирсэн элч Цүнчин дэх «Дун Бао» сониноос Татаармөрөнг Лондонд түргэн буцахыг даалгасан тухай мэдээлжээ. Ийм хэл мэдээ авсан Татаармөрөн тэр даруй Белгиэр дамжин Лондонд буцаж ирэхэд Америкийн Сан-Франциско хотод очиж, тэнд болох Нэгдсэн Үндэстний Байгууллагын зохион байгуулах анхдугаар Их хурлыг сурвалжлах даалгавар өгчээ. Ийнхүү тэрбээр олон улсын хориод сэтгүүлчийн хамт цэргийн 58 онгоцоор хамгаалуулан Европоос мордож, Америкт очжээ.

Татаармөрөнг Нэгдсэн Үндэстний Байгууллагыг үүсгэн байгуулах анхдугаар Их Хурлыг сурвалжлах явцад тэнд байсан хятад иргэд нутгаасаа ирсэн зочныг халуунаар хүлээн авч, элэгсгээр дайлж цайлан, хот орчмоор зугаацуулж байв. Нэг удаа ёслолын зоог барьж байтал Зөвлөлтийн төлөөлөгчдийн бүлгэмийн дарга Молотов хундага өргөж, Дундад улсын төлөөлөгчдийн бүлгэмийн дарга Сүн Чи Ве-д архи барихдаа «Дундад улсын төлөөлөгчдийн бүлгэмийнхэн

«  
**Татаармөрөн Европын дайны талбараас олон тооны мэдээ, сурвалжлага, тэмдэглэл, найруулал бэлтгэж «Дэгүн» сониндоо илгээж байв. Түүний нийтлэл олон нийтийн хүсэн хүлээсэн чухал асуудал байхын зэрэгцээ үнэн бодитой хэргийг өвөрмөц арга барилаар илэрхийлж чаддагаараа Дундад улс төдийгүй Европ дахинд алдаршсан билээ**

Зөвлөлт Холбоот Улсад ирж “Дундад-Зөвлөлтийн нөхөрлөлийн гэрээ” байгуулах тухай зөвлөлдөхийг хүсч байна» гэжээ. Тэрхэн агшинд Татаармөрөн самбаачлан Цүнчинд “бачим цахилгаан” явуулж хоёр их гүрний харилцаанд том ахиц гарах боломжтой болсныг бусдаас түрүүнд зарлан мэдээлсэн ажээ.

»

1945 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 15 цагт Нэгдсэн Үндэстний Байгууллагыг үүсгэн байгуулах ёслолын арга хэмжээ Сан-Франциско хотын Дуу бүжгийн Хүрээлэнд эхэллээ. Энэ бол даян дэлхийд дуурсах онцгой үйл явдал байв. Мөн өдрийн 17 цаг 20 минутад тэрхүү түүхэн үйл явдлын мэдээ Номхон дөлгөөн далайг гатлан ертөнцийн нөгөө бөөрөнд түгэн цуурайтав. Тэрхүү гарамгай үйл явдлын сураг чимээг дамжуулагч нь Татаармөрөн байсан юм. Тэрбээр уг мэдээг зүгээр ч нэг дамжуулсангүй. Сэтгэл хөдөлж,

сэтгүүлчийн ур чадвар зааж мэдээлсэн юм. Иш татъя.

«Үдийн хойнох хоёр цагт гэнэт бороо дусаллаа. Зарим нэг гутрангуй үзэлт улс төрч үүнийг ер бусын совин татлаа гэлцэж байлаа. Гэтэл яг хурал эхлэхийн өмнө бороо зогсож, нарны цацраг эх дэлхийг гийгүүллээ... Дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн 1800 гаруй сурвалжлагч эхлээд суудлаа эзэлцгээв. Тайзны хоёр тал руу хөхөмдөг өнгөтэй шар хөшиг унжиж, шарангуй өнгөтэй тулгуур баганын хооронд дэлхийн 47 улсын төрийн туг алаглан харагдана. Төлөөлөгчид орж ирэхэд сурвалжлагчид яарна. Аппаратнаас гэрэл гялсхийх тоолонд нэг хүн орж ирнэ. Дөрвөн цаг гучин минутад хөгжим зогслоо. Америкийн төрийн явдлын сайд Стединевс Калифорни мужийн дарга болон, Сан-Франциско хотын даргын хамт индэрч гарч ирэхэд Дуу бүжгийн хүрээлэнд цугларсан зочид төлөөлөгчид аянга нижигнэх мэт алга ташицгаалаа. Стединевс ширээн дээрх модон алхыг авч гурвантаа тогшсоноор бүх дэлхийн энх тайвныг сахин хамгаалах байгууллагыг үүсгэх Их Хурал албан ёсоор эхэллээ...» гэхчилэн бичсэн юм. Ийнхүү сэтгүүлч хүн бүрт тохиолдохгүй, бас хэзээ ч дахин давтагдахгүй гарамгай үйл явдлын гэрч болж, халуун сэргэг мэдээг нь даян дэлхийд цуурайтуулах хувь тохиолыг эдэлсэн цорын ганц монгол сэтгүүлч бол Татаармөрөн билээ.

Германчууд 1940 оноос эхлэн Английн агаарын хилийг нэвтрэн хот тосгодыг бөмбөгдөж байснаа, 1944 оны 6 дугаар сараас эхлэн бүр тийрэлтэт сумаар буудаж эхэлжээ. Англичууд Лондон хотыг агаарын дайралтаас хамгаалах бүхий л аргыг хэрэглэж байв. Нэгэн амралтын өдөр Татаармөрөн танилындаа иртэл гэрийн

эзэн эр, эм хоёр өөр хүний цайллаганд уригдсан байжээ. Тэд Татаармөрөнд гэрээ даатгаж орхиод явцгаасан байна. Шөнө болж Татаармөрөнг орондоо орж байтал гэнэт түгшүүрийн дохио хангинаж, төдөлгүй Германы онгоцууд бөмбөгдөж эхлэв. Татаармөрөн унтлагын хувцастайгаа шатны дор орж биеэ далдлав. Гурван давхар орон сууц хоромхон зуур нурж утаа баагин, гал дүрэлзэж эхэллээ. Дайснууд шатаах бөмбөг хаясан байжээ. Аюул өнгөрсний дараа байшин дор булагдсан Татаармөрөнгийн аврал эрэх дууг сонссон аврагчид түүнийг тоосгон дотроос гаргаж авчээ. Хүний газар үхэх аюулаас мултарсан идэрхэн сэтгүүлч ихэд баярласан нь мэдээж.

Дэлхийн II дайн Германы фашистуудын өдүүлгээр эхэлсэн шигээ, бас тэдний ялагдлаар төгсчээ. Дайн дууссаны дараа цуст яргалал үйлдэгсдийг шүүж эхэлсний дотор Германы фашистын хоёр дахь эрх мэдэлтэн Герин тэргүүтэй 230 мянган ялтныг урьдаар шүүж эхэлжээ. Энэ түүхэн үйл явдлын тухай Татаармөрөн «Нюренбергт дайны ялтныг шүүсэн нь» гэдэг тэмдэглэлдээ «Геринийг баривчлах үед биед нь ил нэг юм, далд нэг юм байлаа. Ил авч явсан нь эргэн тойронд нь хорин дөрвөн бүргэдийн дүрс сийлсэн богинохон таяг байв. Америкийн долдугаар армийн дарга Фийч таягаа тушаахыг шаардахад Герин “Энэ бол миний эрх сүрийн бэлгэ тэмдэг юм» гэж татгалзахад Фийч “Одоо чамд ямар ч эрх сүр байхгүй” гэхийг сонсоод тоглоом биш болохыг ойлголоо. Түүний далд нуусан юм нь шаардлагатай үед амиа егүүтгэх хортой эм байжээ. Герин алах ялаар шийтгэгдлээ. Хэрэгтэн унтлагын торгон хүрмээ нөмөрч, гаанс тамхиа аваад жорлонд оров. Харуул хаалганы доогуур цухуйх ялтны хөлийг ажиглаж

байлаа. Герин гаансаа бац мушгиж, дотор нь байсан хорт бодисыг авч залгилаа. Харуул түүний хоёр хөл татвалзаж байхыг хараад хаалгыг онгойлговол Герин нэгэнт үхчихсэн байв» гэхчилэн дүрсэлж бичсэн байна.

Татаармөрөн хэдийгээр монгол хүн боловч хятад, англи хэлээр бүтээлээ туурвидаг байжээ. Түүний сурвалжлах ажлын онцлог нь уран зохиол, нийтлэл хоёрын зааг дээр бүтээлээ туурвидагт оршино. Тиймээс ч судлаачид түүнийг «зохиолч ба сурвалжлагчийг нэгтгэсэн хүн» гэж санал нэгтэй дүгнэдэг байна.

Татаармөрөн хожим яагаад уран зохиолын үйл хэргээ сурвалжлагчийн ажлаар сольсоныг нь сонирхсон сэтгүүлчдийн асуултад хариулахдаа «Би энэ замыг сонгосноо одоо ч зөв гэж боддог. Нэгд: Сурвалжлагч шиг амьдралын гүнд орж чаддаг мэргэжлийг би хэзээ ч олохгүй, Хоёрт: Сонин мэдээг түргэн бичихийг шаардана. Тиймээс хүнийг түргэн шуурхай ажиллахад сургадаг юм. Гуравт: Сонин мэдээллийн ажилтны сэтгэлд уншигчид хоногшиж байдаг. Сурвалжлагч хүн энгийн үед ч олон түмнээс хөндийрдөггүй. Дөрөвт: Сонин мэдээллийн ажилтнууд бодит байдал, ахуй амьдралтай ямагт холбоотой байдаг»<sup>6</sup> гэсэн байдаг.

Тэрбээр «Нэгэн баясангуй үзэлтний өөрийн үг» гэдэг дурсамж нийтлэлдээ «Гучаад оны эхэнд сургуулийн үүднээс гарахын өмнө би амьдралынхаа замыг төлөвлөн тогтоожээ. Тэр нь сурвалжлагчийн ажлаар дамжиж уран зохиолчийн чадварыг олох зам байсан юм. Тавин жилийн дараа эргэцүүлэн бодоход би үндсэндээ тэр л төлөвлөгөөгөөрөө аж төрж иржээ. Би өөрийгөө “ахмад сэтгүүлч” гэж хэлүүлэх болгондоо хязгааргүй их

омогшиж, догдлох сэтгэлээр бялхаж байдаг» хэмээн өгүүлж байжээ.

Татаармөрөн 1933 онд «Гүүр» гэдэг анхны өгүүллэгээ нийтлүүлжээ. Дараа жилд нь «Пин Сүй замаар аялсан сул тэмдэглэл» гэдэг нийтлэлийн бүтээлээ хэвлүүлсэн байна. Тэрбээр уран бүтээл туурвих болсон тухайгаа «Өнгөрсөн жилүүдэд туулж өнгөрсөн амьдрал болон үзэж сонссоноос үлдэж хоцорсон төрөгдлүүдээ үсэг бичигт тэмдэглэн үлдээж, өөрийнхөө явцуухан ертөнцөд уншигчдыг дуудаж ирүүлээд, тэдэнтэй бахдал болоод зовлонгоо хуваалцахын төлөө юм» гэсэн удаатай. Энэ нь утга зохиолд хөл тавьж эхлэх үеийнх нь үзэл бодол байжээ. Тэрбээр хожим сайн нөхөр Бэ Жиний зөвлөснөөр зохиол бүтээлдээ нийгмийн зөрчил тэмцлийг тусгаж, улс төрийн хурц асуудлыг хөндөх өргөн харааг эрхэмлэх болжээ. «Би уужим ухаанаар өөрийгөө мэдрэхийг сурч, хүний өргөн их амьдралыг өөртэйгөө холбон үзэж чадах боллоо» гэсэн нь үүний баталгаа болно.

**Т**атаармөрөн бас «Өнгөрсөн амьдралаасаа юуг нь ард олонд мэдүүлэх хэрэгтэйг бодох тоолонд, хэдийгээр бичгийн хүн биш байсан ч өөрийн эрхгүй бийрээ шүүрэн авахад хүрдэг» гэсэн нь нэг талаар сэтгүүлчийн бүтээл туурвилын бодитой, нөлөөлөх чадвар сайтайг хэлсэн хэрэг боловч, нөгөө талаар сонины нийтлэлээр чийрэгжиж зохиолч болох зорилгоо илэрхийлсэн хэрэг юм. «Лу Сигийн тэнүүл ард» гэдэг нийтлэл нь тэрхүү зорилтынх нь эхний амжилт болсон юм. Уг нийтлэлд Гоминданы ноёрхлын уршгаар идэх, өмсөхөөр гачигдаж байсан ард түмэн Шандунгийн баруун хэсгийг хамарсан их үерийн гамшигт нэрвэгдэж хэрхэн зовж зүдэрч байгааг нийтлэл-уран зохиолыг хослуу-

лах аргаар харуулжээ. Хожим бичсэн «Цус махаар дэвсэгдсэн Диен Миен зам» гэдэг бүтээл нь энэ чиглэлийн бичлэгээр бузгайрсныг нь яруу тод илтгэсэн юм.

Татаармөрөнг тив дэлхийд нэрээ дуурсгасан алдарт сэтгүүлч болоход мэдээж хэрэг хар багаасаа шамдан суралцсан англи хэл чухал суурь болсон нь эргэлзээгүй. Тэрбээр хаана ч, ямар ч явдалтай тулгарсан хэлний бэрхшээлд гачигддаггүй байв. Нөгөө нэг чухал суурь нь өөртөө мэдээлэл олж авах өргөн сүлжээг буй болгож чадсан явдал болно. Тэрбээр хаана ч явсан жирийн иргэд, ажил хэргийн түнш, найз нөхөдтэйгөө эв найртай харилцаж, танилынхаа хүрээг байнга тэлж чаддаг байжээ.

**Б**үтээл туурвилдаа нийтлэл-уран сайхны хосолмол аргыг сонгож, нийгмийн санаа бодлыг гярхай тусгах мөртөө зохиол, нийтлэлийнхээ баатрын дотоод сэтгэлийг товойлгон үзүүлж, санаагаа тод томруун бөгөөд товч яруу илэрхийлдэг, өөрийн гэсэн онцлогтой туурвилын дэг сургуулийг тогтоосон нь алдарт сэтгүүлч Татаармөрөнгийн давтагдашгүй онцлог байжээ.

#### Ишлэл

<sup>1</sup> 1997. “Хүний амьдралын аар саар зүйлс”. Соёл урлаг хэвлэлийн хороо. Хятад хэвлэл. Бээжин. 73 дахь тал.

<sup>2</sup> 1996. Дундад улсын XX зууны найрууллын сонгодог бүтээл. Сюү Чяний боть. Хятад хэвлэл. Бээжин. 236 дахь тал.

<sup>3</sup> Сюү Чянь. “Унах наран” хэмээх найруулал. Монгол сонин, сэтгүүлийн түүхэн тойм. Хөххот. 430 дахь тал.

<sup>4</sup> 1999. Төгсцогт, Вэн Сиү Лэн. Монгол сонин, сэтгүүлийн түүхэн тойм. Хөххот. 447 дахь тал.

<sup>5</sup> 2012. Норовсүрэн Л. XX зууны эхэн үеийн монгол сэтгүүлчид. УБ., 177 дахь тал.

<sup>6</sup> 1997. Шинжааны “Кай зуан” сэтгүүл. II боть, № 7.

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Норовсүрэн Л. 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. УБ.
2. Норовсүрэн Л. 2017. Монгол туургатны хуучин сонин, сэтгүүлийн ойллого. УБ.
3. 1997. “Хүний амьдралын аар саар зүйлс”. Соёл урлаг хэвлэлийн хороо. Хятад хэвлэл. Бээжин.
4. 1996. Дундад улсын XX зууны найрууллын сонгодог бүтээл. Сюү Чяний боть. Хятад хэвлэл. Бээжин.
5. Сюү Чянь. “Унах наран” хэмээх найруулал. Монгол сонин, сэтгүүлийн түүхэн тойм. Хөх хот.
6. Төгсцогт, Вэн Сиү Лэн. 1999. Монгол сонин, сэтгүүлийн түүхэн тойм. Хөх хот.
7. Норовсүрэн Л. 2012. XX зууны эхэн үеийн монгол сэтгүүлчид. УБ.
8. 1997. Шинжааны “Кай зуан” сэтгүүл. II боть.

#### Summary

The historical biography of Tataarmurun, the first international journalist from Mongolian nationals was told in this article with facts.